Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Баяртогтох Дуламханд

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дуусан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Хүүхдийн хоолны шим тэжээл, чанар хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох | | | | | | | |
| 1 | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг өртөгт шилжүүлэн тооцох Засгийн газрын тогтоол боловсруулж, хэлэлцүүлнэ. | Засгийн газрын тогтоолын төсөл | Судалгаа | Судалгаа тооцоол хийх | Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх боломж, шийдлийн талаарх судалгааг 2024 онд Баруун, Хангайн, Төв, Зүүн бүс, Улаанбаатар гэж 5 ангилан, 10 аймаг, 4 дүүргийн нийт 18 сургуулийн санхүү, бусад мэдээлэлд тооцоо хийсэн, мөн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн Орхон аймгийн 17 сургуульд бодит хэмжилт хийж, тооцоолол хийсэн, түүнчлэн Сангийн яам НҮБ-ын Хүүхдийн сан хамтран 5 бүсийн 8 аймгийн 19 сургуульд судалгааг хийсэн. Эдгээр судалгааны үр дүнд үндэслэн үдийн хоолны үйлчилгээг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэхэд нэг суралцагчийн үдийн хоолны түүхий эдийн 2500 төгрөг +1691 төгрөг гэж тооцон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна. Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хувьсах зардлаас хоолзүйч, тогоочийн цалин хөлсийг, орон нутгаас | 1-р сар, 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаанда а гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урсгал зардлыг /цахилгаан, ус/ санхүүжүүлж байгаа нь 1691 төгрөгийн 1124 төгрөгийг эзэлж байна. үлдсэн 567 төгрөг нь хоолзүйч, тогоочийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын зардал, хөдөлмөр хагаалаллын зардал, тоног төхөөрөмжийг засвар, үйлчилгээний зардалд, нөхөн хангалтын зардал юм. Өртөгт суурилсан санхүүлжилтэд шилжүүлэх талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан удирдлагуудад танилцуулсан. Мөн 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан "Хүүхдийн хоол" хэлэлцүүлэгт хоолны түүхий эдийн зардлыг өртөгт суурилсан тогтолцоонд шилжүүлэх талаар танилцуулж, хэлэлцүүлсэн.<br>Хавсралт: 4 файл | | байдал: 100% |
| 2 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | Хуулийн төсөл | Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын төслийн судалгаа | Хуулийн төслийн судалгаа хийж, үзэл баримтлалын төсөл батлуулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна. | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалыг Боловсролын сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд хамтран баталсан. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд сургуулийн хоол хүнсний хангамжид чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүний тогтвортой ханган нийүүлэхэд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тодорхой болгох, нэг хүүхдийн хоолны үйлчилгээний бүрэн өртөгийг тооцон (хувьсах зардлаар) санхүүжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангах, хяналт үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг оруулахаар тусгасан болно. Хуулийн төслийг боловсруулахад салбар хоорондын уялдаа холбоог хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Боловсролын сайдын 2025 оны А/126 дугаар баталсан бөгөөд ажлын хэсгийн 5 гишүүнийг нэрийг солих болсонтой холбогдуулан ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн танилцуулж байна. Боловсролын сайдын 2025 оны | 2-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | А/155 дугаар тушаалаар хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулахад шаардлагата зардал болох 70,000,000 төгрөгийг баталж, “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төслийн танилцуулга болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох бусад судалгаа, тайлан, баримт бичгийн төслийг боловсруулах” БЯ/20250201044 дугаартай зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулсан. Уг тендерт "Гурхайдай" ХХК шалгарч ХҮХ-2025/164 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Зөвлөх үйлчилгээн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах, танилцуулах, хүлээлгэн өгөх цагалварыг баталж, 2025.6.6-ны өдөр аймаг, нийслэлийн боловсрол, эрүүл мэнд, ХХАА-н газрын мэргэжилтэн, сургуулийн захирал, хоолзүйч, нярав, эмч г.м хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогчдын санал авах хэлэлцүүлэгийг зохион байгуулж, судалгааг эхлүүлсэн. Хуулийн төслийг 7-р сард хүлээн авч, хэлэлцүүлэн, 9-р сард ЗГ-т өргөн барих юм.<br>Хавсралт: 4 файл | | |
| 3 | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн төлөвлөгөөг батлуулна | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоол | Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийнэ | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар Засгийн газрын 2020 оны 207 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр”-т туссан арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг баталсан. Удирдамжид заасны дагуу 21 аймаг, нийслэлээс ЗГ-ын 2020 оны 207 дугаар тогтоол, ЗГ-ын 2021 оны 18-р тогтоолд заасан арга хэмжээг шалгуур үзүүлэлт, статистик тоо мэдээлэл, санхүүгийн дүнд өөрсдийн үнэлгээг хийлгүүлэн авч, нягтлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэсэн. | 3-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Урьдчилсан байдлаар “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 10 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд ерөнхий хэрэгжилт 83 хувьтай байна. Мөн “Хоол зүйч” албан тушаалыг төрийн албан тушаалын зэрэглэлд шинээр нэвтрүүлж, орон нутгийн нэмэгдлийг олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь салбарын бодлогын хувьд томоохон ахиц гарсан байна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон шалгуур үзүүлэлтийн биелэлт, зарцуулсан санхүүжилт зэрэгт үндэслэн үе шатын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Хавсралт: 2 файл | | хугацаанда а гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.2. Шим тэжээлийн хэмжээг хангахуйц, тэгш хүртээмжтэй хоол, хүнсний үйлчилгээг нэвтрүүлэх | | | | | | | |
| 4 | Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын хүүхдийн хоол шим тэжээлийн боловсрол, хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах | хоол, шим тэжээлийн боловсрол олгох нэмэлт сургалтын хөтөлбөр, жор технологийн гарын авлага | хоол, шим тэжээлийн боловсрол олгох нэмэлт сургалтын хөтөлбөр туршилт | нэмэлт хөтөлбөрийн туршилтын үнэлгээг хийсэн байна. | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол хүнсний үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хоол шим тэжээлийн боловсрол олгох, хууль эрх зүйн орчны шинэчлэл, санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд талуудын оролцоо, санал шийдлийг гаргаж, хэрэгжүүлэх зорилгоор "Хүүхдийн хоол " хэлэлцүүлгийг Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын сурагчдад зориулсан хоол шим тэжээл-эрүүл мэнд сургалтын нэмэлт хөтөлбөрийг туршин, үр дүнгийн тайланг боловсруулж, сайжруулах ажил хийгдэж байна. 2025.05.20-ны өдөр Чингис хаан Үндэсний музейд зохион байгуулав. Тус арга хэмжээнд УИХ-ын гишүүн, ЕТГ, ТЗТБ болон ЕБС-ын тогооч, хоолзүйч нарын нийт 75 төлөөлөл оролцож салбарын өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлыг хүрээнд санал солилцов. Арга хэмжээг зохион байгуулах хүрээнд дараах бэлтгэл ажлыг ханган ажиллав. Үүнд: - Боловсролын сайдын 2025 оны 5 сарын 08-ны өдрийн "Арга хэмжээ зохион байгуулах, зардал батлах тухай" А/204 тоот тушаал, нэгжийн даргаар арга хэмжээний удирдамж, хөтөлбөрийг батлуулав. - Хэлэлцүүлэгт | 4-р сар, 6-р сар, 8-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаанда а гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зориулан Чингис хаан Үндэсний музей /танхимын түрээс/, Кафейна ХХК /кэйтеринг/, Итагэнси ХХК /шторк/, Хос өнгө пресс ХХЗ /гарын авлага, урилга, хөтөлбөрийн эх бэлтгэл, гарын авлага, стейнд хэвлэл/, иргэн Г.Долгорсүрэн /хоолны үзэсгэлэн зохион байгуулах/ зэрэг нийт 5 гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хханган ажиллав. Хавсралт: 9 файл | | |
| 1.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, нэгдсэн удирлагаар хангах | | | | | | | | |
| 5 | Хоолзүйч, тогоочийн тасралтгүй хөгжлийг хангах давтан сургалтын журам боловсруулах | Сайдын тушаал/журмын төсөл | - | Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт боловсруулах | Хоолзүйчийн мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт болон тогоочийн ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан. Хоолзүйчийн мэргэшлийн зэргийн шалгуур үзүүлэлтийн багш бус ажилчдын шалгуууртай ойролцоо байхаар боловсруулсан боловч, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтад заасан цэцэрлэг, сургуулийн багш, зарим ажилчдын мэргэжлийн нэршилд ороогүй тул тусгайлан батлах боломжгүй байна. тиймээс ГБХНХЯаманд Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлэхээр бэлтгэж байна. Хавсралт: 2 файл | 4-р сар, 6-р сар, 8-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаанда а гүйцэтгэсэн байдал: 50% |
| 6 | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, | Стандартын шаардлага хангасан цэцэрлэг сургуулийн эзлэх хувь | 60 хувь | 35 хувь | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандартын үнэлгээ хийх ажлын удирдамж, үнэлгээний асуулгын төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн. Стандартын үнэлгээнд өмчийн хэлбэр харгалзахгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээнд тавих шаардлага MNS7005:2023 стандартын үнэлгээг үндэсний хэмжээнд зохион байгуулна | | | | үйлчилгээний газар, дотуур байрын гал тогоог 2025 онд бүрэн хамруулж, үнэлнэ. Стандартын үнэлгээний асуумжийг i) барилга байгууламж; ii) хоол үйлдвэрлэлийн газрын зохион байгуулалт; iii) хоол үйлдвэрлэлийн технологи, үйл ажиллагаа; iv) хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж; v) хүний нөөцийн хүрэлцээ, хэрэгцээ; vi) нэгдсэн нэгтгэл гэсэн зургаан хавсралттайгаар боловсруулсан. Стандартын үнэлгээг улсын хэмжээнд орон нутгийн Боловсролын газраас хоол хүнсний болон салбарын хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн нар гүйцэтгэж, БЕГ-ын Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс үнэлгээг нэгтгэж, Боловсролын яаманд ирүүлнэ. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандартыг хэрэгжүүлэх зөвлөмжийн төслийг стандартын бүлэг бүрээр боловсруулсан, эцэслэн хүлээн аваагүй байна.<br>Хавсралт: 3 файл | | 50%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаанда а гүйцэтгэсэн байдал: 50% |
| 7 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдал, ундны усанд шинжилгээ хийх, ус цэвэршүүлэгч төхөөрөмж, | судалгаа, шинжилгээ, аяга таваг угаагч автомат угаалгын машинтай сургуулийн эзлэх жин | аяга таваг угаагч автомат угаалгын машинтай сургуулийн эзлэх жин 16 хувь байна ус цэвэршүүлэгчтэй сургуулийн эзлэх жин 72 хувь | судалгаа, шинжилгээний тайлан | Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт аяга таваг угаагч автомат угаалгын машин ашиглаж буй байдлыг тодруулах зорилгоор, төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байр, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байр хамруулсан судалгааг хийсэн. Судалгаанд 684 сургууль, 999 цэцэрлэг, 382 дотуур байр, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 30 дотуур байр хамрагдсан. Судалгаанд хамрагдсан боловсролын сургалтын 2095 байгууллагын 358 нь байгууллагад 673 ширхэг аяга таваг угаагч автомат угаалгын машин байна. Үүнээс 149 сургууль, 177 цэцэрлэг, 30 дотуур байр, 2 политехникийн коллеж аяга таваг угаагч автомат угаалгын машиныг ашиглаж байна. Судалгаанд хамрагдсан 684 | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаанда а гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аяга таваг угаагч автомат угаалгын машины судалгаанд үндэслэн төлөвлөлт хийх | | | | сургуулиас 532 нь, 999 цэцэрлэгийн 822 нь, 382 дотуур байрын 352 нь, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 30 дотуур байрын 28 нь аяга таваг угаагч автомат угаалгын машингүй байна. Судалгаанд үндэслэн “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслөөс 1,8 тэрбум төгрөгөөр 21 аймаг, нийслэлийн 125 сургуульд цагт 700 аяга таваг угаагч автомат угаалгын машин нийлүүлэхээр худалдан авалтыг зохион байгуулж байна. Боловсролын сайдын 2025 оны А/156 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний орчинд молекул биологийн буюу политеразын гинжин урвал (PCR)-н аргаар халдварын тандан суудалгаа, шинжилгээ хийх”-хэд шаардагдах 99,000,000 төгрөгийг баталж, “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчинд молекул биологийн буюу полимеразын гинжин урвалын аргаар халдварын тандан судалгаа, шинжилгээ хийх” БЯ/20250201043 дугаартай зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулсан. Уг тендерт Праймер ХХК шалгарч 95,000,000 төгрөгийн ХҮХ-2025/165 дугаар гэрээ байгуулсан. Судалгаа, шинжилгээний ажил, хичээлийн жил дуусахаас өмнө авч дуусна.<br>Хавсралт: 7 файл | | байдал: 100% |
| 1.4. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | | | | | | | |
| 8 | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль | биелэлтийн хувь | 2024 оны гүйцэтгэлийн түвшин | 100 хувь | Хууль, тогтоол шийдвэрийн биелэлт, ЗГҮАХАХТ, Ерөнхий сайдын албан даалгавар зэрэг 25 баримт бичгийн 38 арга хэмжээний биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан. Мөн Кайка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх" төслийн зорилтод сургууль болох 40,48,9-р сургууль, Чадавх | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6- | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах | | | | бэхжүүлэх төвийн засвар үйлчилгээний гүйцэтгэгч шалгаруулах арга хэмжээнд мэдээ, мэдээлэл, баримт бичиг, зураг төсвийг хүргүүлэн, шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах бүх арга хэмжээг авч ажиллалаа.<br>Хавсралт: 6 файл | р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 9 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | Мэдээллийн тоо | 2024 оны гүйцэтгэлийн түвшин | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2-р бүрэлдэхүүний хүрээнд "Хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хооллолтод дэмжлэг үзүүлэх аргачлалыг боловсруулан, цэцэрлэг, сургуульд зориулан хэвлүүлсэн. уг гарын авлагад орсон бэрхшээлийн онцлог ялгаа, гарын авлагыг хэрхэн ашиглах, хэн хэн ямар үүрэгтэй оролцох талаар 13 теле хичээл бэлтгэн MEDLE.MN-ний теле хичээл-Эрүүл мэнд, зөв хооллолт буланд байршуулж, түүнийг гарын авлагад QR код болгон байршуулснаар эцэг эх асран хамгаалагч, багш ажилчид ашиглахад хялбар болгосон. https://www.medle.mn/telelesson/99/500/10000493196 3858/99<br>Хавсралт: 1 файл | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Хүүхдийн хоол шим тэжээл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр олон улсын туршлага судалж, эрх зүйн орчинг сайжруулах бодлогын шийдэл боловсруулна. | бодлогын шийдэл боловсруулна. | - | Хүүхдийн хоол шим тэжээл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр олон улсын туршлага судлах, бодлогын шийдэл боловсруулах | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол хүнсний үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хоол шим тэжээлийн боловсрол олгох, хууль эрх зүйн орчны шинэчлэл, санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд талуудын оролцоо, санал шийдлийг гаргаж, хэрэгжүүлэх зорилгоор "Хүүхдийн хоол " хэлэлцүүлгийг 2025.05.20-ны өдөр Чингис хаан Үндэсний музейд зохион байгуулав. Тус арга хэмжээнд УИХ-ын гишүүн, ЕТГ, ТЗТБ болон ЕБС-ын тогооч, хоолзүйч нарын нийт 75 төлөөлөл оролцож салбарын өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлыг хүрээнд санал солилцов. Арга хэмжээг зохион | 6-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулах хүрээнд дараах бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Үүнд: - Боловсролын сайдын 2025 оны 5 сарын 08-ны өдрийн "Арга хэмжээ зохион байгуулах, зардал батлах тухай" А/204 тоот тушаал, нэгжийн даргаар арга хэмжээний удирдамж, хөтөлбөрийг батлуулав. - Хэлэлцүүлэгт зориулан Чингис хаан Үндэсний музей /танхимын түрээс/, Кафейна ХХК /кэтеринг/, Итагэнси ХХК /шторк/, Хос өнгө пресс ХХЗ /гарын авлага, урилга, хөтөлбөрийн эх бэлтгэл, гарын авлага, стейнд хэвлэл/, иргэн Г.Долгорсүрэн /хоолны үзэсгэлэн зохион байгуулах/ зэрэг нийт 5 гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллав.<br>Хавсралт: 9 файл | | |
| 2 | Монгол бичгийн дунд шатны мэдлэг чадварыг эзэмшинэ. | Монгол бичгийн сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлнэ. | - | Дунд шатны түвшний мэдлэг чадвартай болсон байна. | Монгол бичгийн сургалтад 7 хоног бүрийн пүрэв гарагт хамрагдаж байна. | 1-р сар, 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 3 | Төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад суралцаж, | Төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад | дунд хугацааны давхан сургалтын | Төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтыг төгссөн | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн захиргааны албан хаагчийг мэргэшүүлэх ахлах | 1-р сар, 2-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төгсөнө. | суралцаж, төгсөнө. | сертификат | сертификат авсан байна. | түшмэлийн сургалтад 9 багц цагийн хичээлийг судлан, №А5099 дугаартай сертификат авч, амжилттай төгссөн.<br>Хавсралт: 1 файл | | даргын үнэлгээ: 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Баяртогтох Дуламханд /................................................./ Огноо: .........................